



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 9 сарын 7 өдөр

Дугаар 343

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 239 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэнд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан” 2009 оны 283/207 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийн дунд хугацааны үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажлын удирдамжийг хоёрдугаар, үнэлгээний төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үнэлгээг 2015 оны 4 дүгээр улиралд багтаан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хяналт -шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Э.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081209

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 3-р сарын 1-ний өдрийн  
343 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

“Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийн дунд хугацааны  
үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Оюунсүрэн, Аудитын	Хяналт- шинжилгээ, газрын	үнэлгээ,	дотоод дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Пүрэвсүрэн, аудитын	Хяналт- шинжилгээ, газрын	үнэлгээ,	дотоод мэргэжилтэн
Гишүүд:	Г.Базархүрэл, аудитын	Хяналт- шинжилгээ, газрын	үнэлгээ,	дотоод мэргэжилтэн
	Д.Ганзориг, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн			
	С.Гончигсумлаа, газрын	Стратегийн бодлого	төлөвлөлтийн	мэргэжилтэн
	Т.Энхзаяа, зохицуулалт	Халдварт бус өвчний бодлогын	хэрэгжилтийн	хариуцсан мэргэжилтэн
	Д.Нарансүх, зөвлөлийн нарийн	Нийгмийн эрүүл мэндийн мэргэжлийн	салбар	бичгийн дарга
	Ш.Оюунбилэг, салбар	Нийгмийн эрүүл мэндийн	мэргэжлийн	зөвлөлийн гишүүн
	П.Тунгалаг, хариуцсан дарга	Биеийн тамир спортын хорооны	Холбоод	
	Б.Цогтбаатар, захирал	Нийгмийн эрүүл мэндийн	хүрээлэнгийн	
	Ч.Туул, хэрэгжилтийн	Нийтийн биеийн тамир спортын бодлогын	зохицуулах газрын	мэргэжилтэн

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 9 сарын 27 өдрийн  
371 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

“Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийн дунд хугацааны  
үнэлгээ хийх ажлын удирдамж

Улаанбаатар хот

2015.08.27

1. Үндэслэл:

Эрүүл мэнд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2009 оны 283/207 дугаар, тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийн дунд хугацааны үнэлгээг хийж, хөтөлбөрөөр хэрэгжилтийг сайжруулах санал, зөвлөмжөөр хангах

2. Зорилго:

“Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийн дунд хугацааны үнэлгээ хийж, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах санал, зөвлөмжөөр хангах

3. Үйл ажиллагааны чиглэл:


Стратегийн дунд хугацааны үнэлгээг дараах чиглэлээр хийнэ.

- Үнэлгээний ажлын хэсэг байгуулах, арга хэмжээний үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээний хуваарь гаргах, үйл ажиллагааны талаархи тайланг хүлээн авах
- “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, цаашид авах арга хэмжээний зөвлөлдөх уулзалт зохион байгуулах
- Стратегийн шалгуур үзүүлэлтийн биелэлт
- Стратегийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гарсан холбогдох Эрүүл мэндийн болон Хүнс хөдөө аж ахуйн сайдын тушаалын хэрэгжилт
- Хамтран ажиллах байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа
- Үнэлгээний тайланг гаргаж Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэх, шийдвэрийн төсөл боловсруулах
- Нэмэлт шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авна  
Тухайн стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон бусад холбогдох материалд үндэслэн тоон болон чанарын үзүүлэлтэнд үнэлгээ өгнө. Үйл ажиллагааны тайлантай танилцаж, холбогдох эрүүл мэнд, боловсрол, биеийн тамирын байгууллагуудад газар дээр нь стратегийн хэрэгжилттэй танилцана.


4. Хамрах хүрээ:

- Аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар
- Эрүүл мэндийн яамны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв
- Өрх, сумын Эрүүл мэндийн төв

- Бүх шатны боловсролын байгууллага
  - Биеийн тамир спортын газар
  - Боловсрол соёл шинжлэх ухааны яам
5. Хугацаа: 2015 оны 08-10 дугаар сар  
Баримтын судалгааны болон ярилцлагын аргаар үнэлгээ хийнэ.
- А. Баримтын судалгаанд дараах материалыг судлана.
- Хууль (монгол улсын яамны эрх зүйн байдлын хууль, эрүүл мэндийн тухай хууль, хөдөлмөрийн хууль, боловсролын тухай, төсвийн тухай хууль)
  - Засгийн газрын тогтоол (2009 оны 239-р тогтоол)
  - Тушаал (Эрүүл мэндийн сайдын 2009 оны 283/207 тоот)
- Б. Ярилцлагын судалгаанд:
- Биеийн тамир спортын газар
  - Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
  - Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирал Б.Цогтбаатар
  - Нийслэлийн тамгын газрын Нийгмийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн Р.Ягаанцэцэг
  - Нийслэлийн эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн Н.Мэндсайхан
  - Боловсрол соёл шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсрол хариуцсан мэргэжилтэн Г.Туяа
6. Хүрэх үр дүн: Стратегийн хэрэгжилтийн үр дүн гарна.



Эрүүл мэнд, спортын сайдын  
 2015 оны ... сарын ... өдрийн  
 343 дугаар тушаалын 3 дугаар  
 хавсралт



“Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги” –ийн үнэлгээний хуваарь

№	Үйл ажиллагаа	8 сар	9 сар				10 сар			
		IV	I	II	III	IV	I	II	III	IV
1	Ажлын хэсгийн тушаал батлах, ажлын хэсгийн нэгдсэн хурал зохион байгуулах									
2	Үнэлгээний санхүүжилт, хөдөө орон нутгийн хуваарь гаргах									
3	Нэгдсэн үнэлгээ хийх аргачлал гаргах, үнэлгээ хийх									
4	Орон нутагт үнэлгээ хийх									
5	Үнэлгээний дүнг нэгтгэх									
6	ЭМСЯ-ны УЗ-ийн хуралд танилцуулах									